

Хавсралт: Сайтад байршуулах мэдээний агуулга

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ, БИОТЕХНОЛОГИ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР МАГИСТРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР ЗАРЛАГДЛАА.

JCI Progress салбар байгууллага, "Агро-сити" эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба, БНСУ-ын Шинжлэх ухаан, технологийн хүрээлэн (KIST) болон JCI Wonju салбар байгууллагуудын хамтарсан магистрын бүрэн тэтгэлэгт хөтөлбөр зарлагдлаа.

Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын хөдөө аж ахуй, биотехнологи, иргэний болон байгаль орчны инженерчлэлийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулахуйц мэргэжилтэн судлаачдыг бэлдэх зорилготой.

Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд БНСУ-ын Шинжлэх ухаан технологийн хүрээлэнгийн бүрэлдэхүүн сургуулиудын магистрын хөтөлбөрт 1 оюутныг сонгон шалгаруулж бүрэн тэтгэлэгтэйгээр дараах мэргэжлээр суралцуулна. Үүнд:

- Биотехнологи
- Хүнсний биотехнологи
- Иргэний болон байгаль орчны инженерчлэл

Тэтгэлгийн төрөл, хэмжээ:

- Сургалтын төлбөр
- Дотуур байр
- Сар бүр амьжиргааны зардалд ойролцоогоор 1,000,000 вон

Тавигдах шаардлага:

- Эцэг, эх хоёулаа МУ-ын иргэн байх;
- Хөдөө аж ахуйн чиглэлээр бакалаврын зэрэгтэй эсхүл 2026.05.31-ны байдлаар бакалаврын зэрэг авсан байх;
- Бакалаврын дипломын голч дүн 3.0-аас дээш байх;
- Суралцаж төгсөөд "Агро-сити" эдийн засгийн тусгай бүсэд ажиллах;
- Гадаад хэлний мэдлэг IELTS-6, TOPIС-4, TOEIC-277, TOEFL-80 ба түүнээс дээш оноотой байх

Материал хүлээн авах хугацаа: 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 23:00 цаг хүртэл

Материалыг Монгол-Солонгос эсхүл Монгол-Англи хэл дээр бэлдэх ба бүх баримт бичгүүдийг нэг PDF файл болгож progress@jcimongolia.mn и-мэйл хаягт ирүүлнэ. Утас: 99916032, 88048909

Дэлгэрэнгүй мэдээллийг QR кодыг уншуулан авна уу.

